



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/576

Эрдэнэт


Цэргийн дүйцүүлэх алба хаагчдаар үүрэг гүйцэтгүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 /а/, 29.2 дахь заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйл, 2008 оны "Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам"-ын тухай 49 дүгээр тогтоолын 10 дугаар зүйлийн Б заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам"-ын дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа 25 алба хаагчдаар Баян-Өндөр сумын нутаг дэсгэрт 2017 оны 08 дугаар сарын 14-ний өдөр орсон хүчтэй аадар бороо, салхины улмаас үүссэн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд 2017 оны 08 дугаар сарын 14-19-ний хооронд 5 хоног, аймгийн мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хүрээнд аймаг, сумын аюулгүйн нөөцийн өвс ачих, буулгах, хураах ажилд 2017 оны 09 дүгээр сарын 11-нээс 10 дугаар сарын 11-ийг хүртэл 30 хоногийн хугацаатай үүрэг гүйцэтгүүлэхийг Цэргийн штабын дарга /хурандаа Батсуурь/-д даалгасугай.

Хоёр.Цэргийн дүйцүүлэх алба хаагчдаар үүрэг гүйцэтгүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын ажил үүрэг гүйцэтгэхэд шаардагдах 1370000 /Нэг сая гурван зуун далан мянган/ төгрөгийг орон нутгийн цэрэг татлага, дүйцүүлэх албаны цугларалт, бэлтгэл сургуулилтын зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 28 ны өдрийн 34 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



ЦЭРГИЙН АЛБЫГ БИЕЭР ДҮЙЦҮҮЛЭН ХААГЧДААР ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгж	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1.Ажлын багаж хэрэгслийн зардал					
1.	Ажлын бээлийн	хос	40	2000	80000
Бүгд					80000
2.Хоол,цай ундааны зардал					
1.	Хоол /2017 оны 08 дүгээр сарын 14, 15, 16, 17, 18 өдрүүдэд/	25	5 өдөр	6000	750000
2.	Хоол /2017 оны 09 дүгээр сарын 11, 13, 15, 17, 20, 22, 26/	15	7 өдөр	4000	420000
Бүгд					1170000
Тээврийн зардал					
1.	Бие бүрэлдэхүүнийг тээвэрлэх Уаз-452	80	А-80	1500	120000
Бүгд					120000
Нийт					1370000